

## **БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

### **Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар**

#### **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Булган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг хоёр удаа хийж, 12 асуудал хэлэлцэн, 14 тогтоол гаргаж, бусад асуудлаар тэмдэглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэл өглөө.

Төрийн шагнал уламжлах тухай, Аймгийн ИТХ-ын 2021 оны төлөвлөгөөний тухай, Аймгийн ИТХ-ын 2020-2024 онд баримтлан ажиллах чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Аймгийн ИТХ-н шагнал олгох тухай, “Шинэ хөдөө- хөгжил” ОНӨААТҮГ-ын ТУЗ-ын бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай, “БУЛГАН МЭЭЖ” ОНӨХХК-ий бүтэц батлах тухай, “БУЛГАН МЭЭЖ” ОНӨХХК-ий хөрөнгө бэлтгэх саналын тухай, Аймгийн Цагдаагийн газрын үйл ажиллагааны тайлангийн тухай, “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай ЗДТГ-ын ХЭЗХ-ийн даргын мэдээлэл, “Бахархлын өдөр”-ийн тухай, Монгол Улсын төрийн дээд шагналд уламжлах тухай, Бугат сумын сургуулийн барилгын бүтээн байгуулалттай холбоотой гомдол, мэдээллийг шалгасан тухай, Иргэний зөвлөлийн гишүүнийг түр томилох тухай гэсэн асуудлуудыг хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргалаа.

#### **Төрийн захиргааны чиглэлээр:**

Гадаад харилцааны чиглэлээрх тайлан болон Монгол Улсын ЗГХЭГ-ын дарга, Шадар сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг гаргаж, холбогдох газруудад хүргүүлсэн. Булган аймаг, Орхон аймгийн ЗДТГ болон “Эрдэнэт үйлдвэр”ТӨҮГ-тай хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулж, 2 дугаар сард гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан.

Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурал 2021 оны 1 дүгээр сард 4 удаа хуралдаж, цаг үеийн асуудлаар 18 асуудлыг хэлэлцлээ. Шийдвэрлэсэн асуудлаас дурдвал: Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Өргөдөл, гомдлын 2020 оны жилийн эцсийн тайлан. Засгийн газрын тогтоол, шийдвэрийн 2020 оны жилийн эцсийн хэрэгжилт, Улсын аварга малчин, улсын хошой аварга малчин, аварга тариаланч, тариаланч хамт олныг шалгаруулж холбогдох дээд шатны байгууллагад цаг тухайд нь хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2021 оныг аймгийн хэмжээнд “Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх” жилийн аян болон “Бүтээмж-чанарыг сайжруулах жил” болгон зарлаад байна.

Аймаг, сумдын цаг үеийн нөхцөл байдал, өвөлжилтийн явц, хаваржилтийн бэлтгэл ажлын тухай сумдтай 2 удаа цахим хурлыг зохион байгуулсан.

### **Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр:**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 98 шийдвэрийн 194 заалтыг манай аймагт даалгасанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 96.1 хувийн хэрэгжилттэйгээр танилцуулан, аймгийн Засаг даргын 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/63 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлээ.

Аймгийн Засаг даргын 2021 01 дүгээр сарын 04-ний өдрийн баталсан "Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тухай" аймгийн Засаг даргын гаргасан захирамжийн хэрэгжилтэд хяналт-шалгалт хийх удирдамжийн дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүн хяналт-шалгалтын ажлыг аймгийн хэмжээний нийт төр төсвийн байгууллага, хяналтын пост, аймаг, сумын Онцгой комиссын шуурхай штабуудад хийсэн.

2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 16 зорилтын 19 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗДЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, 78.8 хувийн хэрэгжилттэйгээр ЗГХЭГ-ын "Мэдээллийн цахим сан"-д байршууллаа.

Сум, агентлагийн 2020 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" шинэчлэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан журамд өөрчлөлт оруулж, шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирсэн албан бичгийн дагуу 15 дэд хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрийн 70 зорилтын 379 арга хэмжээг ЗГХЭГ-ын "Мэдээллийн цахим сан"-д байршуулж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, 02 дугаар сарын 20-ны дотор хэрэгжилтийг тайлагнана.

Аймгийн ИТХ, ИТХТ-ийн 56 шийдвэрийн 101 заалтад 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн ЗДЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн ИТХ-ийн хуралд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.

## Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Булган аймгийн төрийн сангаар үйлчлүүлэгч төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог хийж гүйцэтгэн 1000 ширхэг төлбөрийн хүсэлтээр 3.9 тэрбум төгрөгийн гүйлгээг дамжуулсан байна.

2020 оны төсвийн баазыг аймаг, сумын төсөв баталсан тогтоолын хамт Сангийн яаманд хүргүүлж төсөв татуулж, аймгийн Байгаль хамгаалах сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган Аудитын газарт хүргүүллээ.

Аж ахуйн нэгж байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайланг шалган хүлээн авч 28 хувьтай баталгаажуулан ажиллаж байна.

2021 оны 01 сард улсын төвлөрсөн төсөвт 62,861.9 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 57,288.2 мянган төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг **91.1%**, аймгийн төсөвт 1,476,915.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 1,260,217.3 мянган төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг **85.3%**, сумын төсөвт 150,995.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 84,253.1 мянган төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг **55.8%** хувь, нийт улс, аймаг, орон нутгийн төсөвт 1,690,771.9 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 1,401,756,6 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг **82.9** хувиар биелүүлэн ажиллалаа.

Орон нутгийн өмчийн газар нь 2 удаагийн нээлттэй, 2 удаагийн хязгаартай дуудлага худалдааг зохион байгуулж, аймгийн хөрөнгө борлуулсаны орлогын дансанд 3,1 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

## Гурав: Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгжийн болон төрийн жинхэнэ албан хаагчаар боловсруулсан. Засаг дарга, Тамгын газрын даргын хууль тогтоомжид тусгагдсан эрх, үүргийн эмхтгэлийг бэлтгэж хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд байгуулагддаг гэрээнүүдийн жишиг загварыг хянаж, бэлтгэн 16 сум 1 тосгон, агентлагуудад файл хэлбэрээр тараасан.

Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд 01 дүгээр сард 2 сумын Засаг даргын 58 захирамж, 16 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж чиглэл хүргүүлэн ажиллалаа.

Иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх зорилтын хүрээнд аймгийн Хууль зүйн туслалцааны төвөөр 14 иргэн үйлчлүүлж хуулийн зөвлөгөө, 7 хэрэгт өмгөөллийн үйлчилгээг авсан байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны 01 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг танилцуулахад 26 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8 хэргээр буюу 23,5 хувиар буурсан. Хутаг-Өндөр, Гурванбулаг, Бүрэгхангай, Хангал, Орхон сумдад гэмт хэрэг өссөн. Тэшиг, Баян-Агт, Дашинчилэн, Хишиг-Өндөр, Могод ижил түвшинд байгаа бол, Сайхан, Сэлэнгэ, Хялганат, Баяннуур, Бугат, Булган сумдад гэмт хэрэг буурсан байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тухайд 8 бүртгэгдэж 5 нэгжээр буюу 62,5 хувиар өссөн үзүүлэлттэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажлын чиглэлээр 01 дүгээр сард хорихоос өөр төрлийн ял шийтгэл эдлэсэн иргэдээс торгох ялын 20 гүйцэтгэх хуудасны 84 921 700 төгрөгний үлдэгдэлтэй, нийтэд тустай ажил хийлгэх ялын 4 гүйцэтгэх хуудасны 687 цагийн үлдэгдэлтэй, эрх хасах ялын 15 гүйцэтгэх хуудасны 9625 хоногийн үлдэгдэлтэй байна. Албадлагын арга хэмжээ авсан тэнссэн 55 иргэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 2, ял хойшлуулсан 2, хөрөнгө орлого хураах 24 гүйцэтгэх хуудсны үлдэгдэл 98 264 000 төгрөг, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2, хугацааны өмнө тэнсэн суллагдсан 14, зөрчлийн 21 гүйцэтгэх хуудасны үлдэгдэл 19 223 000 төгрөг байна.

Шүүх шинжилгээний албан чиглэлээр тус албаны криминалистикийн шинжээч, шинжээч эмч нар нь гэмт хэргийн газрын үзлэгт 18 удаа мэргэжилтнээр оролцож, 54 ширхэг ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэн авч, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох 37, цогцост задлан шинжилгээ хийх 7, криминалистикийн 6, тусгай буюу химийн шинжилгээ 4 хийж, гарын хээний Папилон санг баяжуулах ажлын хүрээнд эрүүлжүүлэгдсэн болон гэмт хэргийн учир шалгагдаж байгаа 18 хүний гарын хээний дардсыг авч, гарын мөр 4, гутлын мөр 8, тээврийн хэрэгслийн мөр 4, бичил мөр 2, эвдлэгч багажийн мөр 3, биологийн гаралтай 2, бусад ул мөр, эд мөрийн баримт 31, бэлгийн холбогдолтой 1, нас тогтоох 3, гэрэл зургийн 873 кадр, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн 4 гарын мөрийг тус тус кодлон нэгдсэн санд оруулан баяжуулсан ба шүүх шинжилгээ нийт 7 удаа хийж шинжээчийн дүгнэлтийг хугацаанд нь гарган ажилласан.

**Дөрөв: Боловсрол, соёл, эрүүл мэнд,**

**нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд**

**Боловсролын чиглэлээр:**

Эрүүл мэнд, БШУС, Сангийн сайдын А\166, А\559\222 тушаал буюу цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоол хүнсний норм, нормативыг хүргүүлж, зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллалаа.

12-р ангийн сурагчдаас элсэлтийн ерөнхий шалгалтын хими, биологийн хичээлийн сорил-3 ыг авч нэгтгэн, анализ хийж сургуулиудад хүргүүлээ.

Олон улсын ЭКО сургууль, цэцэрлэгт хамрагдах хүсэлтэй 10 цэцэрлэг, 5 сургуулийн мэдээллийг УБ хотын БОМСТ руу хүргүүлсэн.

СӨБ-ын Эрхлэгч,арга зүйч нартай “СӨБ-ын хичээл, үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт” буюу сайдын 164-р тушаалын дагуу уулзалтыг хийж, сургалт, үйл ажиллагааны төлөвлөгөө хийх зөвлөгөө зөвлөмжийг өгсөн. 1,2,3,4-р анги удирдсан багш нар, Түүх, нийгмийн ухаан, газарзүйн багш нар, монгол хэл, бичгийн багш нар, дотуур байрны багш, ажилчид, бага боловсролын 5-р анги удирдсан багш нар, дүрслэх урлаг, дизайн технологийн багш нартай цахим хурал зохион байгууллаа.

Булган аймагт тусгай зөвшөөрөл гаргаж стандартад нийцсэн анхны хувийн цэцэрлэг байгуулагдлаа.

“Үндэсний өв, бичиг, соёлыг түгээн дэлгэрүүлэх” жилийн аяныг эхлүүлж Булган аймгийн төрийн албан хаагчдаас үндэсний бичгээр бичих, унших чадварын гарааны судалгааг авч сургалтыг зохион байгуулж эхэллээ.

### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

1 дүгээр сарыг “Осол гэмтлээс сэргийлье” нэрэмжит сарыг аймгийн ЦГ-тай хамтран зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд Ковид-19-ын вакцинд хамрагдах нийт 15245 зорилтот бүлгийн иргэд болон холбогдох байгууллагуудын төрийн албан хаагчдын судалгааг гаргаж, ХӨСҮТ-д хүргүүлсэн.

ЭМГ-ын даргын 2021 оны А/01 дүгээр тушаалаар аймгийн хэмжээний “Тусгаарлан ажиглах байрыг сонгон шалгаруулах ажлын хэсэг”-ийг байгуулж, аймгийн Засаг даргын А/10 дугаар захирамжийг гаргуулсан.

ЭМГ-ын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар Ковид-19-ын үед ажиллах мэргэжлийн багийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг баталсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/04 дүгээр захирамжаар ЕБС-ийн 12-р ангийн сурагчдад давтлага зохион байгуулах болсонтой холбоотой 566 суралцагч, 591 багш, ажилчдыг Ковид-19 илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд хамруулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдын давтлага хичээл эхлэх болсонтой холбоотойгоор БСУГ-ын даргад 02/05 тоот албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.

Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа, үйлчилгээний 23 байгууллагад халдвар хамгааллын дэглэм мөрдөгдөж байгаа байдалд хяналт хийж, албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.

Улаанбаатар болон бусад аймгаас ирсэн 614 иргэдээс асуумж авч, тандалт хийж зөвлөгөө өгч ажилласан.

2020-2021 онд улсын төсвийн санхүүжилтээр үндсэн мэргэжлийн сургалтад суралцах их эмч нартай гэрээ байгуулан 01/08 тоот албан бичгээр ЭМХТ-д хүргүүлсэн.

Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нар болон холбогдох албан тушаалтнуудтай 11 удаа цахимаар холбогдож, цаг үеийн асуудлаар мэдээлэл солилцож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэдээг дүгнэлт хийн, ЭМХТ болон орон нутгийн 8 байгууллагад өдөр тутам тогтмол хүргүүлж ажилласан.

### **Нийгмийн халамжийн чиглэлээр:**

#### **Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээний хүрээнд:**

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 4 иргэнд утсаар өгч, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэлжүүлэв. Сарын мэдээг сар бүрийн 25-ны өдрийн дотор гарган ХХҮЕГ-т хүргүүлж байна.

**Хөдөлмөрийн харилцааны ажлын хүрээнд:** Ажлын байрны цомхтголын асуудлаар 1 иргэнд утсаар зөвлөгөө өглөө.

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлын хүрээнд:** “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н гарын авлага бэлтгэн, хэвлүүлсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөрийн биелэлт гарган ХНХЯ-д хүргүүлэв.

#### **Хөдөлмөрийн бүтээмжийн ажлын хүрээнд:**

Булган сумын 2-р цэцэрлэгийн хамт олонд “Хөдөлмөрийн бүтээмж, түүнийг хэрэгжүүлэх тулгуур асуудлууд” сэдвээр сургалт явуулж, нийт 29 ажилтныг хамрууллаа. Аймгийн хэмжээнд “Бүтээмж-чанарыг сайжруулах жил” болгон зарласантай холбогдуулан аймгийн удирдамж, төлөвлөгөө, болзлын шалгуур үзүүлэлт зэргийн төслийг гарган АЗДТГ-ын НБХ-т хүргүүлэв.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 2021 оны 1-р сарын байдлаар 1143 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаагаас шинээр 42 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгүүлсэн байна. Ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг 7 иргэнд гарган, Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэв. Ажил олгогч 8 байгууллагаас 22 ажлын байрны захиалга авч Орон нутгийн телевиз болон зарын цэгүүдээр зар байршуулан сурталчилгааг явуулж ажиллалаа.

2017-2020 оны Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх судалгааг сумдаас авч нэгтгэсэн. 2020 оны материалыг цэгцэлж, архивлаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2014-2020 оны хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийг хүн тус бүрээр нь үлдэгдлийг тооцож, санхүүгийн шинэчилсэн програмд оруулахад бэлдэж байна.

### **Нийгмийн халамжийн чиглэлээр:**

Халамжийн сангаас 2021 оны 1-р сард 2719 иргэнд 468,8 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт олгогдсон. Е халамжийн програмаар 3071 иргэнд 146,8 сая төгрөгийн тэтгэмж олгогдсон. Бүх сумдаас тэтгэвэр тэтгэмжийн хувийн хэрэг, нэг удаагийн хөнгөлөлтийн материалыг хүлээн авч хяналт, хянан олголтыг хийсэн. Мөн УБГ-аас нас барсан иргэдийн жагсаалтыг авч 46 иргэнийг WAIS болон Е халамжийн програмд тулгалт хийн 27 иргэний үйлчилгээг зогсоов. Халамжийн сангийн олголтын талаар мэдээлэл авахаар биечлэн ирж уулзсан 17 /үүнээс 2 өргөдөл/, утсаар холбогдсон 22 иргэний асуудалд хариу өгч шийдвэрлэсэн. 2020 оны 11,12 сарын хувийн хэргүүдийг баталгаажуулан, сумдад хүргүүлээ.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрүүдийн 2020 оны хэрэгжилтүүд болон Аймгийн хэмжээний 90-с дээш настай ахмадын судалгааг гаргаж аймгийн ЗДТГ-ын НБХ-т хүргүүлээ.

Аймгийн “Хүүхдийн эрхийн хууль, эрх зүйн хороо”-ны 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн дүнг танилцуулах болон 2021 оны төлөвлөгөөнд санал оруулах хуралд оролцлоо.

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа, ЕНАЛАМЖ систем, ӨМНС, хүүхдийн мөнгө, хүнсний эрхийн бичиг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал болон бусад үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл авахаар биечлэн ирж уулзсан 3 иргэн, утсаар холбогдсон 15 иргэнд мэдээлэл өглөө.

Халамжийн сангийн 2021 оны 1-р сарын санхүүжилтийг хийж мөнгийг олгож байна. Тухайн сарын мэдээ тайланг ХХҮЕГ, Төрийн сан, Статистикийн хэлтэст хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Мөн Халамжийн сангийн 4-р улирлын болон 2020 оны 12-р сарын тайлан мэдээг шилэн дансанд хугацаанд нь оруулж тайлагнасан. ОНОТХҮйлчилгээний 2018, 2019, 2020 онд Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ болон хамрагдсан иргэд, зарцуулсан мөнгөн гүйлгээний судалгааг гарган ХХҮЕГ-т хүргүүлэв. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүд Нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулж байгаа Байнгын асаргаанд байдаг хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, тэдгээр хүүхдүүдийн эцэг эхчүүд асран хамгаалагч нарт сургалт зохион байгуулах талаар онлайн хуралд хамрагдаж мэдээлэл авсан.

Мөн Булган аймгийн хэмжээнд хавдраар өвчилсөн хүүхдүүдийн нарийвчилсан судалгааг гарган ямар шалтгаанаар хавдар үүсч байгаа болон хавдартай хүүхдүүдэд хэрхэн тусламж үйлчилгээг үзүүлэх талаар Хавдартай хүүхдүүдийн анхдугаар

зөвлөгөөнд оролцлоо. Мөн цар тахлын үед ХБХЭМБНХ-н салбар комиссын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хуралдааныг хэрхэн зохион байгуулж байгаа талаар тайланг гарган ХНХЯ-нд хүргүүлсэн.

Цар тахал гарсантай холбогдуулан нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг иргэдийн дансанд шилжүүлэн картжуулах ажлыг хийж байгаа ба дансгүй иргэдэд данс нээж нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулж байна.

2020 онд нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлсэн Төрийн болон ХААН банктай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэн ХХҮЕГ-т хүргүүлсэн ба тус 2 банк нь нийгмийн халамжийн үйлчилгээг цаг хугацаанд нь иргэдийг чирэгдүүлэлгүй ямар нэгэн зөрчил дутагдал гаргалгүй ажилласан тул гүйцэтгэлийг 100% дүгнэсэн.

2021 оны 1 дүгээр сарын байдлаар 871 өрхийн 2344 том хүн, 2188 хүүхэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/13 тоот тушаалаар хүнсний эрхийн бичгийн босго оноо аймагт 310,0 оноо болж шинэчлэгдсэний дагуу сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн шийдвэрийг үндэслэн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд шинээр хамруулахаар Булган сумын 3 өрхийн мэдээллийг ХХҮЕГ-т хүргүүлж, 7 том хүн 7 хүүхдийг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд шинээр хамрууллаа. 1 дүгээр сарын хүнсний эрхийн бичгийн олголтыг хийж, үйлчилгээ үзүүлдэг 27 дэлгүүрт жагсаалтыг хүргүүлж хүнсийг олгож байна.

Булган сумын цахим хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 13 өрхийн картын хугацаа дууссаныг дахин шинээр захиалахаар Төрийн банканд албан тоот хүргүүлээ. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд шинээр хамрагдсан Булган 6 өрхийн хувийн хэргийг нээж цахим картыг захиаллаа

### **Гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр:**

Шүүхээс ирсэн захирамжийн дагуу гэр бүлийн асуудалд шинжээчийн баг томилогдон Орхон суманд ажиллалаа. Гэр бүлийн боловсролын нийт 10 дугаар хичээлийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан цахим орчинд олон нийтэд хүргэж 759 хүний хандалт авсан байна. 2020 онд хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр албан байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичгийг баталсан. Үүнд /Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Боловсролын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.

Шүүхээс ирсэн захирамжийн дагуу Орхон суманд очиж ээж Л.Сувдын гэрт очиж орчин нөхцөлийн үнэлгээ болон судалгаа хийж шинжээчийн баг ажиллалаа. 2020.01.20-нд шүүхээс ирсэн захирамжийн дагуу Хангал сумын гурван эвэрт баг дээр эцэг



Б.Ундрахын гэрт очиж орчин нөхцөлийн үнэлгээ болон судалгаа хийж шинжээчийн баг ажиллаж шүүхэд мэдээллийг хүргэсэн.

“Цодгор хүү 2020 “ шатрын тэмцээн 2020.01 сарын 08-ны өдөр зохион байгуулагдсан. Тус тэмцээнд 15 сумын 107 хүүхэд багачууд оролцон өрсөлдсөн.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:**

#### **Мал аж ахуйн талаар :**

2020-2021 онд 16 сум 1 тосгон, 75 багийн 9.1 мянган малчин өрхөд 3.6 сая толгой мал өвөлжиж байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн дутууг бэлтгэх хөрөнгийг шийдвэрлэсэн. Аймгийн хэмжээнд өвс худалдах иргэн, аж ахуй нэгжийн судалгааг гаргасан.

Баяннуур, Гурванбулаг, Рашаант, Орхон, Дашинчилэн, Могод, Сайхан, Бүрэгхангай сумдад Өвөрхангай, Архангай, Төв, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Орхон аймгийн 290 малчин өрхийн 158,4 мянган толгой мал отроор өвөлжиж байна.

Дээрх бүртгэлтэй отрын малчдаас гадна бүртгэлгүй машин, мотоциклтой адууны отор Баяннуур суманд 16000, Гурванбулаг суманд 2896, Дашинчилэн суманд 4170 толгой буюу нийт 23066 толгой адуу дээрх 3-н сумын малчдын өвөлжөө, хаваржааны бэлчээрийг идэж малчдын дунд зөрчил үүсгэж байна

Цаг үеийн мэдээллийг долоо хоногийн 3 дахь өдөр сумдаас мал аж ахуй өвөлжилт, малын хорогдолийн мэдээг авч, нэгтгэн аймгийн удирдлагууд, ОБГ, ХХААХҮЯ-нд уламжилж байхаар болсон.

Улсын аварга малчны тодорхойлолт хүлээн авч Засаг даргын зөвлөлд оруулж Улсын хошой аварга малчинд Дашинчилэн сумын малчин Д. Лавмэдэх, Улсын аварга малчинд Хишиг-Өндөр сумын малчин О.Батжаргал, Могод сумын малчин Б. Нямдаваа, Хутаг-Өндөр сумын малчин Г.Гантулга, Баян-Агт сумын малчин Д.Жаргалтогтох, Гурванбулаг сумын малчин Ө. Дашзэвэг, Орхон сумын малчин С.Мөнх-Эрдэнэ нарын материалыг ХХААХҮЯ-нд хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **Хүнс, газар тариалангийн талаар:**

Мах, сүүний анхдугаар аяны 2016-2020 оны хэрэгжилтийг гаргаж хүргүүлээ.

Аймгийн төвийн худалдаа эрхлэгчдийн төлөөлөл бүхий 13 хүн хамруулсан уулзалтыг хийж, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 14 -ны өдрийн А/22 дугаар “Орон нутгийн худалдан авалтыг дэмжих” тухай захирамжийг тараан өгч, ЭМГ-ын дарга Д.Нарантуяа бизнес эхлэгчдэд эрүүл ахуйг хэрхэн хангах, халдваргүйжүүлэлт хэрхэн хийх, ямар бодис ашиглах болох Ковидын цаг үеийн мэдээллийг өглөө.

Уулзалтаар Худалдаа эрхлэгчид нь цар тахлын өдрүүдэд манай аймаг орон нутгийн хувьд эрүүл бүс тул аливаа бизнесийн үйл ажиллагааг дэмжин ажиллах хэрэгтэй байна гэсэн хүсэлтийг уламжилж, аймгийн Худалдаа эрхлэгчдийн холбоогоор дамжуулан хүсэлтийг Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрийг гарган, дахин уулзаж Худалдааны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг хэрхэн тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэхээр өндөрлөлөө.

Улсын аварга тариаланч хамт олон 3, аварга тариаланч 4 хүний материалыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж, ХХААХҮЯ-нд хүргүүллээ.

2021 оны аймгийн нийт үр тариа, тосны ургамал, тосны ургамал, төмс, хүнсний ногоо тариалах талбай, ургацын аймгийн төлөвлөгөөг тодотгон боловсруулж ХХААХҮЯ-нд хүргүүллээ.

## **Зургаа: Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын чиглэлээр**

### **Байгаль орчны чиглэлээр:**

#### **Ойн чиглэлээр:**

Булган аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 06/01 тоот удирдамжийн дагуу Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч, хөдөлмөрийн байцаагчтай хамтран Булган аймгийн Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Бугат суманд үйл ажиллагаа явуулдаг сум дундын ойн анги, байгаль хамгаалагч, ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар “Ойн тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Хөдөлмөрийн тухай” хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийн байдлыг газар дээр үзэж зөрчлийг арилгах албан шаардлагыг мэргэжлийн хяналтын байцаагч өгч ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 184 дугаар тогтоолоор Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоосныг сумдад хүргүүлэн 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж ажиллах талаар заавар зөвлөгөө өглөө. Мөн сум дундын ойн анги, байгаль хамгаалагчдад хөнгөлөлтийн хувь хэмжээг ямар модонд бичих талаар чиглэл өгч ажилласан.

#### **Усны чиглэлээр:**

Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагч 3 аж ахуйн нэгжид Усны тухай хууль, тогтоомжийг сурталчилж, ус ашиглуулах дүгнэлт гаргуулах талаар зөвлөмж өглөө.

Унд ахуй, бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар шинээр худаг гаргах талаар 2 иргэн, 2 аж ахуйн нэгжид холбогдох хууль, тогтоомж болон бүрдүүлэх материалын талаар зөвлөгөө өглөө.

2021 онд аймгийн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх 10 булаг, шандны судалгааг гарган аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүллээ.

Ус үндэсний хөтөлбөрийн биелэлт, усны тоолууржуулалтын мэдээ болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Усны газарт хүргүүллээ.

Сэлэнгэ, Хануй голын сав газрын захиргаатай 2021 онд усны тоо бүртгэл болон рашааны физик шинж чанар, химийн найрлагыг тодорхойлох ажлыг хамтран хэрэгжүүлэх талаар санал солилцож, ажлын удирдамж боловсрууллаа.

**Нөхөн сэргээлт, тусгай хамгаалалтай газар нутаг, БОНБЕУ-ний чиглэлээр:** Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын нэмэлт өөрчлөлт оруулах саналд бичил уурхай эрхлэгч нөхөрлөлүүдийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх талаар санал боловсруулж хүргүүлэв.

Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 11 аж ахуйн нэгжүүдэд 2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж урьдчилан хянуулахад Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8 дахь заалт “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ” гэсэн зорилтын хүрээнд Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт эвдэрч олон жил орхигдсон нөхөн сэргээлт хийгдээгүй 127 га талбайгаас тодорхой хэмжээгээр гүйцэтгэх ажлыг Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгах чиглэл хүргүүллээ.

Татварын хэлтсээс Баяннуур сумын нутаг дэвсгэрт MV-017590 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч “Гялалзах Эрдэнэс” ХХК нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 23, 24 дүгээр зүйлийн дагуу татвар төлөгчөөр бүртгэгдээгүй судалгаа авлаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2017 оны 8 дугаар сарын 17-ний өдрийн А/226, А/182 дугаар тушаалын дагуу Бүрэгхангай сумын бичил уурхай эрхлэгч нөхөрлөлүүдийн 2020 оны нөхөн сэргээлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны 01 сарын 21-ний өдрийн А/31 дүгээр захирамжаар “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг батлуулав. Аймгийн хэмжээнд уул уурхайн олборлолт, авто зам, дэд бүтэц, бусад нөлөөллийн улмаас эвдэрч олон жил орхигдсон талбайн судалгааг гаргаж Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүллээ.

**Хог хаягдлын чиглэлээр:** Аймгийн хэмжээнд энгийн хог хаягдлын хураамжийн судалгааг аймгийн ЗДТГ, Татварын хэлтэстэй хамтран гаргаж, БОАЖЯ-нд хүргүүллээ.

Булган сумын ЗДТГ, булган сумын ТҮА-нд хог ангилан ялгах хогийн савны ашиглалтыг сайжруулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах тухай албан бичгийг хүргүүллээ.

Коронавируст халдвар (Ковид 19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.5, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Засгийн газрын

2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу БОАЖЯ-наас гаргах “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг зохицуулах түр журам”-ын төсөлд оруулах саналыг ХОХБТХ, Төрийн сан, Татварын хэлтэстэй хамтран гаргаж хүргүүлсэн.

БОАЖГ-аас Орчны бохирдлын үндэсний хороотой хамтран ажиллах саналыг гаргаж хүргүүлсэн.

### **Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:**

#### **Газар зохион байгуулалтын чиглэлээр:**

“Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д 2663 арга хэмжээ, сумын ИТХ-р газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийсэн 9 сумын 250 арга хэмжээг оруулан хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллаа.

2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт 12 дугаар сарын 31-ний байдлаар эрхзүйн харилцаа үүсгэхээр 1963 нэгж талбарын 3201,33 га газар олгохоор төлөвлөгдсөнөөс 1402 нэгж талбарын 2840,17 га газрыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, өмчлүүлсэн байна. ХАА-н газарт 136 арга хэмжээний 322432,9 га газрыг хамгаалах, сайжруулах, ашиглуулахаар төлөвлөгдсөнөөс 31500 га талбайд хортон мэрэгчийн устгал хийж, 80305,6 га бэлчээрийн газрыг сэлгэн ашиглаж, 186485 га газрыг бэлчээрийг өнжөөж амраасан, шинээр 28 худаг гаргахаар төлөвлөгдсөнөөс 19 худаг шинээр гаргасан. 3826 га хадлангийн талбайг ашиглуулж, 5 булаг шандны эхийг хашиж, 4574,1 га талбайг сум дундын отрын бэлчээрт авч, 135,1 га газрыг хог хаягдлыг цэвэрлэх, элдэгдэж ухагдсан газрыг нөхөн сэргээх арга хэмжээг тус тус авч хэрэгжүүлэв. Нэмэлт тодотгол хийсэн 250 арга хэмжээнээс 227 нэгж талбарыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлсэн байна.

16 сумын ИТХ-р батлагдсан 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тус бүр газар зохион байгуулалтын цахим системд 2164 арга хэмжээг оруулан хянаж бүрэн баталгаажуулан [egazar.gov.mn](http://egazar.gov.mn) сайтаас иргэд мэдээллийг харах боломжийг бүрдүүлээ.

ГЗБГЗЗГ-с газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбон, иргэд, олон нийтэд зориулсан веб системийг хэрэглээнд гаргаж, газартай холбоотой үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд системийн нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг үе шаттайгаар холбогдох үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна.

#### **Геодези зураг зүйн чиглэлээр:**

Сумдын 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зургийн мэдээллийн санд шинээр байгуулагдсан болон өөрчлөгдсөн объект, хаягийн мэдээллийн сангийн 1:1000-ны масштабтай зургийн баяжилт, геодезийн байнгын цэг тэмдэгтийн хувийн хэрэг, тооллого бүртгэл, шинэ эринд шилжсэн цэг тэмдэгтийн судалгааг ГЗБГЗЗГ-т 2020 оны 01/22 тоот албан бичгээр хүргүүлэв.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Улсын хэмжээнд хаягжуулалтын ажлыг эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г сумдын Засаг дарга нарт 2021 оны 01/42 албан бичгээр хүргүүлсэн бөгөөд уг ажлын төлөвлөгөөний дагуу 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр сумдын газрын даамлууд харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хаягийн мэдээллийн системийг ашиглан зам, гудамж, талбай, нэгж талбар, үл хөдлөх хөрөнгөнд хаяг, нэр, дугаар олгох, засварлах ажлыг хийж гүйцэтгэх чиглэлээр цахим сургалтыг зохион байгуулан ажиллаа.

### **Суурь судалгаа, газрын мониторингийн чиглэлээр:**

Газарт учирсан хохирол, хамгаалалт болон өргөдөл хүсэлт шийдвэрлэлтийн мэдээ, газрын маргаан тэдгээрийн шийдвэрлэлт, хяналт шалгалтын мэдээ, БОХ-2-1, БОХ-2-2 зэрэг Газрын нэгдмэл сангийн 2020 оны тайлан мэдээг ГЗБГЗЗГ-ын холбогдох мэргэжилтнүүдэд хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

2021 оны 01-р сарын 13-ны өдөр ГЗБГЗЗГазар суурь судалгаа, газрын мониторингийн хэлтсээс зохион байгуулсан Газрын мониторингийн системээр захиалгат хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлтийг баталгаажуулж ажиллах цахим сургалтад хамрагдсан.

Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн 08/32 тоотын дагуу улсын тусгай хамгаалалттай газар нутагт иргэн аж ахуй нэгж байгууллагад газар эзэмшүүлж, ашиглуулсан талаарх судалгааг гаргаж 2021 оны 01/34 албан тоотоор хүргүүлсэн. ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн 02/40, 02/43 тоотын дагуу ашиглалтгүй орхигдсон тариалан болон атаршсан газрын мэдээ, мониторингийн 204 цэгийн судалгааг сумдаас нэгтгэх ажил хийгдэж байна.

### **Газрын төлбөр, үнэлгээний чиглэлээр:**

Газрын төлбөр, татварын системийг 2020 оны 01-р сарын 09-ний өдрөөс эхлэн нэвтрүүлсэнтэй холбогдуулан газрын кадастрын мэдээллийн системд нөхөн бүрдүүлэлт болон, шинээр газар эзэмшигч ашиглагч нарын газрыг тухай бүр бүртгэж мэдээллийн сангийн баяжилтыг хийж байгаа болон өмнөх оны нэгтгэсэн мэдээллийг татварын хэлтэст 2021 оны 01/66 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

2021 оны газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэлийг үүсгэн татварт шилжүүлэх талаарх зөвлөмж зөвлөгөөг даамлуудад утсаар мэдэгдэж 2021 оны 01/36 тоот албан бичгээр сумдад хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллаж байна. Булган, Бугат, Хангал сумдын газрын төлбөрийн хувь хэмжээнд өөрчлөлт орж батлагдсантай холбоотой кадастрын мэдээллийн санд тухайн сумын ИТХ-ын тогтоолыг төлбөрийн бүстэй холбон, зориулалт тус бүрээр итгэлцүүрийг шинэчлэн мэдээллийг оруулаа.

Газрын биржийн цахим програм хангамжид шинээр томилогдсон Баян-Агт, Хангал сумдын даамлын мэдээллийг 2021 оны 01/48 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлэн эрх нээлгүүлсэн.

**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**